



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 14 өдөр

Дугаар 35

Хэрлэн сум

XXXV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын XXXV хурал 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 14:30 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 94 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. 2020 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд үүсэж болзошгүй цаг агаарын аюулт үзэгдлийн урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг танилцуулах:

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга М.Алтаннавч,

2. Онцгой байдлын ерөнхий газраас 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх шуурхай мэдээ” ирснийг танилцуулах:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга,

Онцгой комиссын гишүүн М.Алтаннавч-д

1.1.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, аймаг, сумын Онцгой комиссыг цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг,

Хоёр.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа нарт:

2.1.Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаанд хүндрэл учирхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг,

Гурав.АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

3.1.Хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

4.1.Зэргэлдээ аймгуудын холбогдох мэргэжлийн байгууллагуудтай цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг тогтмол солилцож, болзошгүй үед зам хаах асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэхийг,

Тав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Сумдын Засаг дарга нарт цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар албан бичиг хүргүүлэхийг,

Зургаа. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн дарга, Онцгой комиссын гишүүн Г.Отгонбаатар-т:

6.1.Цахилгаан дамжуулах агаарын шугам, тулгууруудад үзлэг шалгалт хийж аюулгүй байдлыг хангаж, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг,

Долоо. Агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт:

7.1.Сумдад байгаа салбар нэгжүүдэд албан бичгээр үүрэг чиглэл өгч ажиллахыг,
7.2.Цаг агаарын мэдээ, мэдээллийг ажилтан, албан хаагч нарт шуурхай хүргэхийг,
7.3.Болзошгүй аюулт үзэгдэл, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай харилцан ажиллахыг,

Найм.Сумын Засаг дарга нарт:


8.1.Цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ, хүчтэй салхи шуурганы үеэр объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэд, малчдад мэдээллийн хэрэгсэл болон "Багц мессеж"-ээр олон удаагийн давтамжтайгаар хүргэхийг,


8.2.Хүчтэй салхи, шуурганы үеэр иргэд, жолооч нарт хол ойрын замд зорчихгүй байхыг анхааруулах, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийн найдвартай байдлыг хангаж бензин, шатахууны нөөцтэй, дулаан хувцастай зорчихыг сануулахыг,

8.3.Иргэд, малчдыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, салхи шуурганд төөрөх, малтайгаа уруудахаас сэргийлэх, малаа ойрын бэлчээрт хариулах, бага насны хүүхдийг малд явуулахгүй байхыг анхааруулахыг,

8.4.Хүчтэй салхи шуурганд барилга байгууламжийн дээвэр хийсэх, нурахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахыг,

8.5.Болзошгүй аюулт үзэгдэл, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай харилцан ажиллахыг тус тус үүрэг болгов.

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА